



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Ардчилсан намын хаягийн өөрчлөлтийг  
улсын бүртгэлд бүртгэх тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, Танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, Ч.Хосбаяр, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Д.Батбаатар, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, С.Соёмбо-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Ардчилсан намын дарга Л.Гантөмөрөөс ирүүлсэн “Хаягийн өөрчлөлт бүртгүүлэх тухай” өргөдлийг Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяагийн илтгэснээр хянан хэлэлцээд **ТОДОРХОЙЛОХ** нь:

Ардчилсан намын дарга Л.Гантөмөрөөс 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр ирүүлсэн өргөдөлдөө: “... Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7.1-д “Хуулийн этгээдийн улсын бүртгэл дараах төрөлтэй байна: ...7.1.3.хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлтийн, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.6-д “Улсын дээд шүүх улс төрийн намыг энэ хууль болон бусад хуульд заасны дагуу бүртгэнэ”, 10.1-д “Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна: ... 10.1.3.хуулийн этгээдийн ерөнхий захиргаа оршин байгаа газрын албан ёсны хаяг, хэрэв байнгын ажиллагаатай ерөнхий захиргаа байхгүй бол тухайн хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн оршин байгаа газрын хаяг” гэж тус тус заасан байна.

Улсын дээд шүүхийн цахим хуудас дахь улс төрийн намын бүртгэлийн цахим санд Ардчилсан намын хаягийн бүртгэл “Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Сүхбаатарын талбай-8, Ардчилсан намын байр” гэж, хувийн хэрэгт “Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Сүхбаатарын гудамж, Ардчилсан намын төв байр-1” бүртгэгджээ. Уг хаягт байрлах Ардчилсан намын төв байрыг буулгаж газар эзэмших эрхийг 2013 онд Улаанбаатар банканд шилжүүлсэн.

Монгол Улсын дээд шүүхийн 2023 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн нийт шүүгчийн хуралдааны 10 дугаар тогтоолоор Ардчилсан намын дарга буюу намыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдээр Л.Гантөмөрийг бүртгэж шийдвэрлэсэн бөгөөд “Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн Өргөн чөлөө, Шинэ дэвшилтэд холбооны байр” гэж бүртгэнэ үү” гээд, Шинэ дэвшилтэд холбоотой байгуулсан “Ажлын байрны түрээсийн гэрээ”, Ардчиллын төлөө намуудын нэгдэх Их хурлын 2000 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хуулбар болон байрны Фото зураг, итгэмжлэл, тэмдэгтийн хураамж төлсөн баримт зэргийг хавсарган ирүүлжээ.

## ҮНДЭСЛЭХ нь:

Ардчилсан намын хаягийн өөрчлөлтийг тус намын мэдээлэлд бүртгэж шийдвэрлэв.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.5-д зааснаар намын хаягийн өөрчлөлт бүртгүүлэх өргөдөл нь улс төрийн намын улсын бүртгэл, хуулийн этгээдийн хувийн хэргийн агуулгад заавал тусгах мэдээлэлд хамаарч байна.

Ардчилсан намын дарга Л.Гантөмөрөөс “Хаягийн өөрчлөлт бүртгүүлэх тухай” өргөдөл, түүнд хавсаргаж ирүүлсэн баримт нь “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 1.4. “Улсын дээд шүүх нь Улс төрийн намын тухай хуульд нэрлэн заасан ... намын хаягийн өөрчлөлтийг бүртгэх, ... бүртгэлийг эрхлэн бүртгэнэ”, 3.12. “Намын баримт бичгийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэхэд энэ журмын хавсралт №2А-д заасан баримт бичгийн бүрдэл хангана”, 3.14. “..., намын баримт бичгийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт ... бүртгэлийг хийлгэх өргөдлийг Улсын дээд шүүхээс баталсан маягтын дагуу гаргаж, намын дарга гарын үсэг зурна” гэж заасантай нийцжээ.

Иймд, Ардчилсан намын дарга Л.Гантөмөрөөс ирүүлсэн Ардчилсан намын хаягийн өөрчлөлтийг тус намын улсын бүртгэлийн мэдээлэлд бүртгүүлэх хүсэлтийг хангаж шийдвэрлэх хууль зүйн үндэслэлтэй гэж нийт шүүгчийн хуралдаанаас үзэв.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, 22 дугаар зүйлийн 22.4-т заасныг баримтлан Ардчилсан намын хаягийг “Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн Өргөн чөлөө, Шинэ дэвшилтэд холбооны байр” гэж тус намын улсын бүртгэлийн мэдээлэлд өөрчлөн бүртгэсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ, ШҮҮГЧ

Д.МӨНХТУЯА